



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тонхил сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/197/НА-СТА-ТШЗ

|   |  |
|---|--|
| <p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br/>Алтай хот 2024 он</p> | <p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа<br/>Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a><br/>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br/>Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a><br/>“Ариун төгс оршихуй аудит” ХХК-ийн<br/>Ахлах аудитор: Г.Баялаг<br/>Утас: 99023656 Цахим хаяг: <a href="mailto:ariuntugsorshihuiiaudit@gmail.com">ariuntugsorshihuiiaudit@gmail.com</a></p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024. 02. 22 № 54

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тонхил сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тонхил сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын нормативын хэмжээг шинэчлэн тогтоосон байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Чиглэл батлах тухай" 2022 оны А/500 дугаар тушаалын дагуу багш, байгууллагын гүйцэтгэлийг үнэлсэн байна.

### Аудитын гол асуудал

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 220,166.4 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 240, 241 дүгээр тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

### Бусад асуудлын хэсэг

Тайлант онд төсвийн захирагчийн 12 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 37 арга хэмжээг 100 хувь буюу бүрэн, 8 арга хэмжээг 70 хувь буюу нийт дүнгээр 95 хувиар биелүүлж биелэлтийг хүргүүлсэн боловч дээд байгууллагаас ажлыг дүгнээгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

0702700199

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

| Үзүүлэлт  | 2022.12.31          | 2023.12.31          |
|---|---------------------|---------------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>                  |                     |                     |
| Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 150,404.50          | 160,371.80          |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 969,777.50          | 915,080.90          |
| <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>1,120,182.00</b> | <b>1,075,452.70</b> |
| Нийт өр төлбөрийн дүн                             | 1,321.10            | 1,687.50            |
| Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 1,118,860.90        | 1,073,765.20        |
| <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>1,120,182.00</b> | <b>1,075,452.70</b> |
| <b>Үйл ажиллагааны орлогын дүн</b>                |                     |                     |
| Үйл ажиллагааны зардлын дүн                       | 2,260,982.60        | 1,564,340.00        |
| <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>1,114,246.00</b> | <b>-45,095.70</b>   |
| Үйл ажиллагааны нийт үр дүн                       | 1,114,246.00        | -45,095.70          |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>    |                     |                     |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 4,614.90            | 1,118,860.90        |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт  |                     |                     |
| Тайлант оны үр дүн                                | 1,114,246.00        | -45,095.70          |
| <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>1,118,860.90</b> | <b>1,073,765.20</b> |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                   |                     |                     |
| Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 1,145,280.80        | 1,555,091.80        |
| Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 1,062,530.50        | 1,500,891.40        |
| <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>82,750.30</b>    | <b>54,200.40</b>    |
| <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | <b>-27,584.00</b>   | <b>-30,889.00</b>   |
| <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 | <b>-</b>            | <b>-</b>            |
| <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>55,166.30</b>    | <b>23,311.40</b>    |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | -                   | 55,166.30           |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 55,166.30           | 78,477.70           |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>                |                     |                     |
| <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          | <b>-</b>            | <b>1,531,756.50</b> |
| Урсгал зардал                                     | -                   | 1,531,756.50        |
| Хөрөнгийн зардал                                  | -                   | -                   |
| <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             | <b>-</b>            | <b>1,555,067.90</b> |
| Улсын төсвөөс санхүүжих                           | -                   | 1,257,846.70        |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих                    | -                   | 292,748.80          |
| Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас             | -                   | 4,472.40            |
| Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл                         | -                   | 78,477.70           |

### Гурав. Аудитын илрүүлэлт:

Залруулагдаагүй нийт 0.8 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 0.8 сая төгрөгийн 1 зөрчил<sup>1</sup> илэрч төлбөрийн акт тогтоосон.

### 3.1 Төлбөрийн акт

1. Сахилгын шийтгэлтэй хүлээсэн 3 албан хаагчид нийт 0.8 сая төгрөгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлтэй албан тушаалтанд олгосон урамшууллыг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

### Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр                          | Нийт алдаа |     | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |     | Үүнээс     |     |              |     | Зөвлөмж |   |
|---|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|---|
|   |            |     |                                   |     |                          |     | Залруулсан |     | Залруулаагүй |     |         |   |
|   | Тоо        | Дүн | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн | Тоо        | Дүн | Тоо          | Дүн |         |   |
| Тонхил сумын Ерөнхий боловсролын сургууль |            |     | -                                 | -   |                          |     |            |     |              |     | -       | - |
| Дүн                                       |            | -   | -                                 | -   |                          | -   |            | -   |              | -   | -       | - |

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр                          | Нийт зөрчил |            | Үүнээс        |            |                 |            |          |          |                                      |                     |   |          |
|---|-------------|------------|---------------|------------|-----------------|------------|----------|----------|--------------------------------------|---------------------|---|----------|
|   |             |            | Төлбөрийн акт |            | Албан шаардлага |            | Зөвлөмж  |          | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |          |
|   | Тоо         | Дүн        | Тоо           | Дүн        | Тоо             | Дүн        | Тоо      | Дүн      | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн      |
| Тонхил сумын Ерөнхий боловсролын сургууль | 1           | 0.8        | 1             | 0.8        | 1               | 0.8        | -        | -        | -                                    | -                   | -   | -        |
| <b>Дүн</b>                                | <b>1</b>    | <b>0.8</b> | <b>1</b>      | <b>0.8</b> | <b>1</b>        | <b>0.8</b> | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b>                             | <b>-</b>            | <b>-</b>  | <b>-</b> |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр       | Нийт зөрчил |          | Үүнээс        |          |                 |          |          |          |
|---|-------------|----------|---------------|----------|-----------------|----------|----------|----------|
|   |             |          | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |          | Зөвлөмж  |          |
|   | Тоо         | Дүн      | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн      | Тоо      | Дүн      |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил  |             |          |               |          |                 |          |          |          |
| Тонхил сумын Ерөнхий боловсролын сургууль | -           | -        | -             | -        | -               | -        | -        | -        |
| <b>Нийт дүн</b>                           | <b>-</b>    | <b>-</b> | <b>-</b>      | <b>-</b> | <b>-</b>        | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> |

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |          |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|----------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Өөрчлөлтгүй             | Хязгаарлалттай | Сөрөг    | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |          |                            |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9        | 10                         |
| 1 | ТШЗ                         | 1                        | 1                           | -                  | -               | 1                       | -              | -        | -                          |
|   | <b>НИЙТ</b>                 | <b>1</b>                 | <b>1</b>                    | <b>-</b>           | <b>-</b>        | <b>1</b>                | <b>-</b>       | <b>-</b> | <b>-</b>                   |